



PRESTIGE

ДОХИОЛОЛ, ХАМГААЛАЛТ, АСААЛТЫН СИСТЕМ



Алсаас
асаах



Температур
мэдэрч асаах



Давтамжтай
асаах



Тогтмол нэг
цагт асаах



APS997E

VOXX APS-997E



АНУ улсын Prestige брэндийн энэхүү дохиолол нь АНУ, Канадын зах зээлд хамгийн их борлуулагддаг бүтээгдэхүүн бөгөөд АНУ, Канадын цаг агаарт шалгагдаж баталгаажсан бүтээгдэхүүн тул Монголын эрс тэс уур амьсгалд хамгийн тохиромжтой дохиолол юм.


Бүтээгдэхүүний онцлог:

- Саадгүй орчинд 750м зайд, саадтай орчинд 100-300м зайд удирдах, мэдээлэл хүлээн авах боломжтой
- Гадны биет автомашинд хүрэхэд дуут дохиогоор анхааруулга өгч автомашиныг халдлагаас хамгаална
- Алсаас удирдлагаар хөдөлгүүрийг асаана
- 2 болон 4 цагийн давтамжтайгаар машиныг асааж халаана.
- Салоны температурыг мэдэрч -17 хэмийн хүйтэн болсон үед машиныг асааж халаана.





Дохиоллыг идэвхижүүлж, хаалга цоожлох

Удирдлагын  товчлуур дээр нэг удаа дарна. Дохиолол идэвхжиж хаалга цоожлогдох ба дуут дохио нэг удаа дуугарч ослын гэрэл нэг анивчиж дохиолол идэвхижсэнийг илтгэнэ. Удирдлаган дээр  дүрс гарч удирдлагын дуут дохио нэг удаа дуугарна.

Санамж: Дохиоллыг идэвхжүүлэх команд өгсний дараа дуут дохио 3 удаа дуугарч анхааруулбал аль нэг хаалга дутуу хаагдсаныг илтгэх ба дэлгэцэд  дүрс гарч сануулга өгнө. Хаалгыг хаасны дараагаар дохиоллыг дахин идэвхжүүлнэ үү.


Дохиоллыг ажиллагаанаас гаргаж хаалга онгойлгох

Удирдлагын  товчлуурыг 1 удаа дарахад бүх хаалга онгойж дохиолол ажиллагаанаас гарна. Энэ үед ослын гэрэл болон дуут дохио 2 удаа дуугарах ба удирдлагад  дүрс гарна.



Автомашин халдлагад өртсөн дохиог унтраах

Дохиолол ажиллагаанд орсон үед машинд гаднын биет хөнгөн хүрэхэд машины дуут дохио дуугарч, анхааруулга өгнө.

Хэрэв автомашинд хүчтэй цохилт мэдрэгдвэл ослын гэрэл болон дуут дохиогоор тасралтгүй анхааруулга өгч, удирдлагад дуут дохиогоор машин халдлагад өртсөнийг сануулна. Дохиоллыг унтрааж хэвийн байдалд оруулахыг хүсвэл  түгжих товчлуурыг 1 удаа дарахад дуут дохио зогсож хэвийн ажиллагаанд шилжинэ.



Удирдлаганы дууг хааж чичиргээний горимд оруулах:

Хурал зөвлөгөөн болон дуу чимээ гаргаж болохгүй олон нийтийн газар энэхүү горимыг идэвхижүүлэх нь тохиромжтой. Энэ горимын үед автомашинд доргилт мэдрэгдэхэд удирдлаганд ирэх мэдээлэл бусдад саад болохгүйгээр зөвхөн чичиргээгээр ирнэ.

Горимыг идэвхижүүлэхдээ:

F болон **U** товчлуур дээр зэрэг 1 удаа дарна. Энэ үед дэлгэцэнд **U** дүрс гарч чичиргээний горимд шилсэнийг илтгэнэ. Чичиргээний горимоос гарахыг хүсвэл дээрхи үйлдлийг давтан хийнэ.

VALET горим буюу дохиоллын ажиллагааг хаах

Энэхүү горимыг идэвхжүүлснээр удирдлагаар хаалга цоожилж онгойлгох үйлдэл хэвийн ажиллах боловч удирдлагаар машинаа асаах, хүн хүрэхэд дохиолол дуугарах үйлдэл ажиллахгүй. Автомашинаа угаалгах, олон нийтийн газар дохиоллыг ажиллуулахгүй байхыг хүсвэл энэхүү горимыг ашиглах нь тохиромжтой.



Идэвхжүүлэхдээ:

1. Түлхүүрээ түлхэнэ.
2. PB товчлуурыг антенаа дээрхи гэрэл астал буюу 5 сек турш удаан дарна.
3. Удирдлага дээр ZZ үсэгний дүрс гарч энэхүү горим амжилттай идэвхжинэ.

Санамж: Энэхүү VALET горимыг идэвхжүүлсэн үед антенаа дээрх лед гэрэл байнгын асаалттай байх болно. Эргэн хэвийн ажиллагаанд оруулахыг хүсвэл дээрхи үйлдлийг давтан хийх ба дохиолол хэвийн ажиллагаанд орж антенаа дээрх лед гэрэл унтарна.




Автомашинг алсаас асаах

Удирдлагын  товчлуур дээр 2 секундийн дотор 2 удаа дарна. Автомашин асмагц ослын гэрэл анивчиж удирдлагад  дүрс анивчиж автомашин асаж байгааг илэрхийлнэ.

Автомашин ассанаас хойш 10 минутын турш асаалттай хэвээр байх ба энэхүү хугацаа дуусмагц автоматаар унтарч дохиолол хэвийн ажиллагаанд шилжинэ. Автомашин асаалттай байх хугацааг 5,10,15,20 минут болгон өөрчлөх боломжтой.

(www.cardoctor.mn ээс дэлгэрэнгүй зааврыг харах)

Асаалтын хугацаа дуусахаас өмнө машинаа унтраахыг хүсвэл удирдлагын  товчлуурыг 2 удаа дарах ба автомашин унтарч ослын гэрэл 2 удаа анивчин машин унтарсныг илтгэнэ.

Санамж: Дараах нөхцөлүүдийн үед систем автомашиныг асааж чадахгүй болохыг анхаарна уу.




1. Автомашин урд копут нээлттэй.
2. Автомашин арааг Parking дээр тавиагүй.
3. Тоормосны гишгүүр гишгэгдсэн.
4. Гар тоормос татаагүй.
5. Машин-удирдлага 2-ийн зай хэт хол буюу сүлжээ хүрэхгүй үед



Цагийн давтамжаар асаах:

Автомашинаа 2 юм уу 4 цаг тутамд автоматаар асааж халаах боломжтой. Давтамжаар асаах горимыг дараах зааврын дагуу идэвхжүүлснээр тодорхой хугацааны давтамжтайгаар хөдөлгүүр автоматаар асч халаах үйлдлийг хийх болно.

Давтамжийн асаалтийг идэвхижүүлэхдээ:

1.  болон  товчлуурыг 1 удаа зэрэг дарна. Удирдлагын дэлгэцэд  дүрс гарч давтамжийн асаалтын тохиргоо идэвхэжнэ.
2. Түлхүүрээ ON руу түлхээд OFF руу хариулна.
3. 10 сек дотор удирдлагын асаах товчлуурыг 4 удаа жигд хурдтай дарна.

Ослын гэрэл болон дуут дохио 4 удаа дуугарч давтамжийн асаалтын горим амжилттай идэвхэжсэнийг илэрхийлнэ. Дуут дохио дуугараагүй бол үйлдлийг дахин хийнэ үү.

Санамж: Давтамжийн асаалтын горимыг идэвхжүүлснээс хойш 48 цагийн хугацаанд автоматаар асаалт хийх ба 48 цаг дуусмагц эсвэл удирдлагаар хаалга онгойлгосны дараа энэхүү горим нь автоматаар цуцлагдана. Удирдлагаар хаалга онгойлгосон бол горимыг дахин идэвхжүүлнэ үү.

Давтамжийн асаалтын хугацааг өөрчлөх:

Давтамжаар асах хугацааг үйлдвэрээс 4 цагт 1 удаа асахаар тохируулсан байдаг. Асах хугацааг 2 цаг тутамд 1 удаа асахаар өөрчлөх боломжтой. Хугацааг өөрчлөхийг хүсвэл дараах алхмын дагуу тохируулна уу.

1. Автомашины цонхонд наасан дохиоллын антен дээрх товчлуурыг дарна
2. Товчлуураа дараатай чигээр нь түлхүүрийг ON руу түлхээд OFF хариулна
3. А) 10 сек дотор товчлуураас гараа аваад дахин 2 удаа хурдан дарна. 2 цаг тутамд асах тохиргоо амжилттай хийгдсэн бол 5 сек дотор автомашины дуут дохио 2 удаа дуугарч ослын гэрэл 2 удаа анивчих болно.



В) Харин 10 сек дотор товчлуураас гараа аваад дахин 4 удаа дарна. 4 цаг тутамд асах тохиргоо амжилттай хийгдсэн бол 5 сек дотор автомашины дуут дохио 4 удаа дуугарч ослын гэрэл 4 удаа анивчих болно.



Температураар асаах горим

Энэхүү горимыг идэвхжүүлснээр салоны температур -17 хэмээс доош хүйтэн болсон үед автомашин автоматаар асааж халаах үйлдлийг хийнэ. Уг горимыг идэвхжүүлэхээс өмнө машинаас гарч дохиоллын удирдлагаар хаалга цоожлон дохиоллыг идэвхжүүлсэн байх ёстой.





+  товчлуурыг зэрэг 1 удаа дарна. Дэлгэц дээр  дүрс гарч температураар асаах горим идэвхжих ба автомашины салоны температур -17 градус хүрэхэд автоматаар хөдөлгүүрийг асааж халаана.

Санамж:



1. Температураар асаах горим нь удирдлагаар хаалга онгойлгосон тохиолдолд удирдлагын дэлгэцэд дээрх термометрийн дүрс унтарч температурын асаалтын горим идэвхгүй болох тул цоожилсны дараа дахин идэвхжүүлнэ үү.
2. Температурын асаалтын горимыг идэвхжүүлснээс хойш систем нь машины салоны температурыг 2 цаг тутамд 1 удаа шалгах ба тухайн үед салоны температур -17 хэм хүрсэн тохиолдолд асаах үйлдлийг хийх ба -17 хэм хүрээгүй тохиолдолд асаах үйлдлийг хийхгүй.

Удирдлагаас салоны температур шалгах

1. Удирдлагын  болон  товчлуурыг зэрэг нэг удаа хурдан дарна.
2. Удирдлага дуугарч дэлгэцэд салоны температурын төвшин харагдана.

Удирдлагын дууг хааж чичиргээнд оруулах









Хурал зөвлөгөөнтэй үед эсвэл шөнийн цагаар удирдлагын дууг хааж бусдад саад болохгүйгээр зөвхөн чичиргээгээр машинаас мэдээлэл авах боломжтой.

1.  +  товчлуурыг нэгэн зэрэг 2 сек турш удаан дараад авна.
2. Дэлгэцэд чичиргээний дүрс гарна. Удирдлага дуугарахгүй зөвхөн чичиргээгээр дохио өгнө.

Дуут дохиог сэргээхийг хүсвэл үйлдлийг давтаж хийнэ.



Удирдлагын цаг, сэрүүлэг тохируулах

1. Удирдлагын  товчлуурыг дуут дохио дуугартал буюу 5 сек турш удаан дарна. Дэлгэцэд цагийн орон анивчиж тохиргоо хийхэд бэлэн болсныг илтгэнэ.
2.  болон  товчлуурыг дарж цагийн оронг тааруулна
3.  товчлуурыг дахин 1 удаа дарахад минутын оронд шилжиж минутын орон анивчиж эхэлнэ.
4.  болон  товчлуурыг дарж минутын оронг тааруулна.
5.  товчлуурыг дахин дарснаар сэрүүлэг тохируулах горимд шилжих ба дээрх зааврын дагуу тааруулна.
6.  товчлуурыг 5 сек орчим удаан дарснаар бүх тохиргоог санах ба тохиргооны горимоос гарна.

**Тусламж:**

Удирдлагын батарей дууссан эсвэл эвдэрсэн үед дохиолол дуугарч эхэлбэл хэрхэн унтраах вэ?

1. Автомашины хаалгыг онгойлгоно. Дохиолол дуугарч эхэлнэ.
2. Автомашины түлхүүрийг ON түлхэнэ.
3. 5 секундйн дотор машины шилэнд наасан антены товчлуурыг нэг удаа дарна.

Ингэснээр дуут дохио унтарч, дохиолол идэвхгүй горимд шилжих ба удирдлагаар цоожлох хүртэл дахин ажиллахгүй.

**Баталгаа:**

Манай дохиоллын системийг сонгосон танд баярлалаа. Энэхүү дохиоллын систем нь суурилуулснаас хойш 2 жилийн баталгаат хугацаатай бөгөөд дараах нөхцөлүүдэд баталгаат хугацаа хамаарахгүй болно.

1. Дохиололд ус чийг орсон, эд ангиудыг задалж засварласан, автомашиныг холбоход үүссэн цахилгааны гэмтэл, дохиоллын удирдлагад ус орох, унагаах зэрэг механик нөлөөллөөс үүдсэн гэмтэл.
2. Баталгаат хугацааны бичгийг үрэгдүүлсэн, засварласан тохиолдолд

Суурилуулсан:.....он.....сар.....өдөр

Машины марк.....Дугаар.....

Суурилуулсан механик.....

Тамга:

PRESTIGE



Хаяг: Хан уул дүүрэг, Хүннү
Моллын баруун хойно
Доктор Яармаг салбар

Лавлах Утас: 1800-1937

Инжинерийн зөвлөгөө: 98103103

Web site: www.cardoctor.mn